
ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЭЛ

ХОТЫН ЗАХЫН ХОРООЛМЫН КЕЙС



ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХУЧИРХИЙЛЭЛ

ХОТЫН ЗАХЫН ХОРООЛМЫН КЕЙС

Энэхүү судалгааг Нээлттэй нийгэм форумын арга зүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр Нийгмийн ажлын үйлчилгээ, үнэлгээний төв, Хүүхдийн эрх хамгаалал төв ТББ-ын судлаачид хамтран гүйцэтгэв.

Судлаачид:

Т. Амаржаргал (Ph.D)

Г. Золжаргалан (MA)

Я. Мөнхзүл (MA)

Т. Эрхэмбаяр

Г. Энхжаргалан

© Нээлттэй Нийгэм Форум, 2015

Уг кейс судалгааг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

DDC

370

3-236

ISBN-978-99973-63-99-2

Агуулга

Удиртгал	4
Нэгдүгээр бүлэг: Залуучуудын дундах хүчирхийллийн томъёолол	8
Хоёрдугаар бүлэг: Залуучуудын дундах хүчирхийллийг бууруулахад нөлөөлөх арга хэмжээ	13
Гуравдугаар бүлэг: Судалгааны үр дүн: Судалгаа явуулсан орон нутаг дахь залуучуудын дундах хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал	16
Дүгнэлт	21
Санал, зөвлөмж	24

Удиртгал

Хүчирхийлэл нь голдуу бусдын нүднээс далд үйлдэгддэг тул нийтлэг дүр төрхийг нь судлан тогтоож, нэгдсэн тодорхойлолт гаргахын тулд нэлээд судалгаа, ажиглалт хийх шаардлагатай. Түүнчлэн хүчирхийлэл нь хувь хүн, гэр бүл, хамт олон, нийгмийн гээд олон хүчин зүйлийн хавсарсан нөлөөллийн үр дүн байдаг тул нийтлэг хэв маяг, хэлбэр загварт оруулахад хэцүү. Тийм ч учраас судалгааны тодорхой нэг дизайн гарган судлах боломж муутай энэ үзэгдлийн тухай нэгдсэн тодорхойлолт дэлхийн хэмжээнд бараг үгүй, илрүүлж ойлгохын тулд улс орнууд өөр өөрийн арга зүйгээр судлан хэмжих шаардлагатай болдог. Эцсийн дүндээ хүчирхийллийн цар хүрээ, шалтгаан нөхцөлийг нухацтай судалсан нь дэлхийн хэмжээнд Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага, АНУ-ын Өвчлөлийг хянах төв гэсэн цөөн хэдэн байгууллага байна.

Гэхдээ хүчирхийлэл нь үйлдсэн болон өртсөн хүн, тэдний гэр бүл, найз нөхөд, цаашилбал орон нутаг, улс үндэстэнд бие, сэтгэлийн дарамт, эрүүл мэндийн болон эдийн засгийн хохирол, бүтээмжийн доройтол зэрэг янз бүрийн түвшний хохирол учруулж байдаг тул нийгэм, хүн амын бодлогын нэгэн чухал чиглэл болж явах ёстой ажээ. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага 4 жил тутамд хийдэг “Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа”-нд хүчирхийллийг залуу хүмүүсийн дундах нас баралтын ноцтой шалтгаан болж байгааг тогтоогоод энэхүү эрсдэлт зан үйлийн нөхцөл байдал, шалтгаан, үр дагаврыг судалж, урьдчилан сэргийлэх стратегиудыг боловсруулан танилцуулж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын 2009 оны тайланд 15-24 насныхан хүчирхийлэлд хамгийн их өртдөг ба нас ахих тутам хүчирхийлэлд өртөгсдийн хувь хэмжээ бүүрч байгааг мэдээлжээ. Хүчирхийллийн төрөл хэлбэр дотроос дарамтаас үүдэн амь насаа хорлох, хүмүүсийн хоорондын хүчирхийллийн улмаас амь насаа алдах, ноцтой гэмтэл авах, хөгжлийн бэрхшээлтэй болох явдал их байна. Хүчирхийлэл үйлдэж, түүнд өртөх хамгийн өндөр магадлалтай 15-24 насны өсвөр, залуу үеийнхэнд чиглэсэн хүчирхийллээс хамгаалах бодлого, хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх нь хүчирхийллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд үр нөлөөтэй байдаг гэж зөвлөжээ.

Монгол Улсад хийгдсэн цөөн хэдэн судалгаанд хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийн холбогдолтой зарим тоо баримт байгаа нь албан ёсны статистик мэдээгээр бус голдуу судалгааны явцад илэрсэн тохиолдлууд байна. Залуучуудын дундах хүчирхийллийн далайц, түүний илрэх хэлбэр,

цаана нь оршиж байгаа шалтгаан нөхцөлийг тухайлан судалсан чанарын судалгаа хараахан хийгдээгүй байна.

Дээрх үндэслэлүүдийг харгалзан Нийгмийн ажлын үйлчилгээ, үнэлгээний төв ТББ болон Хүүхдийн эрх хамгаалал төв ТББ хамтран өсвөр болон залуу насныхны дундах хүчирхийллийн асуудлаар чанарын судалгаа хийж гүйцэтгэлээ. Энэ кейсийн судалгаа нь хотын захын нэг хорооллын өнөөгийн нөхцөл байдлын шууд тусгал болж байгаа утгаараа Монгол орны нөхцөл байдлыг бүрэн төлөөлж чадахгүй. Гэхдээ энэхүү судалгааны дүн нь тодорхой нэг орон нутгийн нийгмийн бодлогоор зохицуулж болох асуудлуудыг илрүүлж цаашилбал, төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогод хамааралтай байж болох зарим асуудлыг хөндөж гаргаж байгаагаараа чухал юм.

Улаанбаатар хотын захын хороололд түшиглэн хийсэн энэхүү судалгааны тайлан нь үндсэн 3 бүлэгтэй. Нэгдүгээр бүлэг буюу “Залуучуудын дундах хүчирхийллийн томьёолол” хэсэгт ямар үйлдлийг хүчирхийлэл гэж авч үзэх, түүнийг судлах шалтгаан нөхцлийг авч үзсэн бол хоёрдугаар бүлэг буюу “Залуучуудын дундах хүчирхийллийг бууруулахад нөлөөлөх арга хэмжээ” хэсэгт гол төлөв бодлогын асуудлыг хөндсөн болно. Харин гуравдугаар бүлэг буюу “Судалгаа явуулсан орон нутаг дахь залуучуудын дундах хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал” хэсэгт кейсийн судалгааны үр дүн, дүгнэлтийг танилцууллаа. Төгсгөлд нь дүгнэлт зөвлөмжийг танилцуулав.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаа нь кейсийн судалгааны арга зүйгээр залуучуудын дундах хүчирхийллийн нөхцөл байдлыг шинжлэн, шалтгаан үр дагавар, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох зорилготой байв.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ:

1. Тодорхой орон нутгийн залуучуудын дунд гарч байгаа хүчирхийллийн төрөл хэлбэр, үүнийг таслан зогсоохын тулд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тодорхойлох
2. Олон улсын судалгааны зөвлөмжид үндэслэн тухайн орон нутагт залуучуудын дунд хүчирхийлэл гарахад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс, хүчирхийлэл даамжрахаас сэргийлж буй хамгаалагч хүчин зүйлсийг тодорхойлох
3. Улмаар тухайн орон нутагт хэрэгжүүлж болох бодлогын чиглэлийг тодорхойлох зэрэг болно.

Онцолж дурдахад, уг судалгаанд кейсийн судалгааны арга зүйг ашигласан тул зөвхөн тухайн орон нутгийн өвөрмөц онцлогийг тусгасан дүгнэлт, зөвлөмж нь бүх орон нутагт хамааралгүй байх магадлалтай. Гэхдээ орон нутгийн онцлогоос гадна өсвөр болон залуу насныханд нийтлэг хамааралтай агуулга бас багтсан болно.

Энэ судалгаагаар бид дараах асуултуудад хариулт авах зорилго тавьсан болно:

1. Тухайн орон нутагт залуучуудын дунд ямар төрлийн хүчирхийлэл гарч байна вэ?
2. Хүчирхийлэл гарч байгаа нь ямар шалтгаантай вэ?
3. Залуучуудын дундах хүчирхийлэл хаана, хэзээ ихэвчлэн тохиолдож байна вэ?
4. Хүчирхийлэл ямар үр дагавар авчирч байна вэ?
5. Хүчирхийллийг хэн, хэрхэн шийдвэрлэж/зохицуулж байна вэ?

Судалгааны үр дүнд тухайн орон нутгийн удирдлагад бодлого, хөтөлбөртөө ашиглаж болох, мөн Монголын өсвөр үе, залуучуудын нөхцөл байдлыг ойлгоход туслах мэдээлэл олж авсан юм.

Судалгааны үе шат, бүтээгдэхүүн

Судалгааг үндсэн хоёр үе шаттайгаар хэрэгжүүллээ.

1. **Судалгааны бэлтгэл үе:** Энэ үе шатанд кейсийн судалгааны арга зүйд суралцан, кейсд хамаарах болон хамаарахгүй үзүүлэлтүүдээ тодорхойлох, судалгааны орон нутгаа сонгох, аргачлалаа боловсруулах ажлуудыг хийсэн.
2. **Мэдээлэл цуглуулах шат**
 - а) **Илрүүлэх шатны судалгаа:** Судалгааны талбар болох Баянзүрх дүүргийн 28 дугаар хорооны оршин суугчид, хорооны захиргааны ажилтнуудыг хамруулсан асуулга, ганцаарчилсан ярилцлагаар сүүлийн 2-3 жилд гарсан хүчирхийллийн тохиолдлуудыг илрүүлэх судалгаа хийлээ. Мөн орон нутгийн зураглал хийж, хорооны иргэдийн амьдралын хэв маяг, хүртэж буй үйлчилгээ, тулгарч болох эрсдэл зэргийг тодрууллаа.
 - б) **Кейсийн судалгаа:** Залуучуудын дунд гарсан хүчирхийллийн тодорхой кейсүүдийг нарийвчлан судалж нөхцөл байдал, шалтгаан, үр дагавар, авсан хариу арга хэмжээ зэргийг ганцаарчилсан ярилцлагаар тодруулж баримтжуулав. Ярилцлагад хүчирхийлэлд өртсөн хүмүүсээс гадна тэдний гэр бүлийн гишүүд, найз нөхөд, мөн холбогдох албаны хүмүүсийг хамрууллаа.

Судалгааны дизайн

Кейсийн судалгаа нь тухайн судалж буй үзэгдлийн тодорхой тохиолдлыг судлах замаар асуудал үүсэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлс, нөхцөл байдлыг нь хамтатган өргөн хүрээнд судалдаг чанарын судалгааны арга юм.¹ Энэ арга зүй нь үзэгдэл, илрэлийн цаана байгаа хүчин зүйлсийг гаргаж ирэх сайн талтай ч тодорхой тохиолдлын өвөрмөц онцлогийг бүрэн дүүрэн тусгадаг тул гарсан дүгнэлтийг ерөнхийлж бусад тохиолдолд хамруулах боломжийг хязгаарладаг онцлогтой. Уг судалгааны хувьд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн өнөөгийн нөхцөл байдал туссан тул бусад орон нутаг, цаг үед хамааруулахдаа болгоомжтой хандах хэрэгцээ гарч байгаа юм. Кейсийн судалгааны энэ сул талыг нөхөн гүйцэлдүүлэхийн тулд бид олон улсын судалгааны тайлан, зөвлөмж, гадаад орны сайн туршлага зэргийг судалж, тайландаа мэдээлэл болгон ашигласан болно.

Судалгааг Баянзүрх дүүргийн 28 дугаар хорооны нутаг дэвсгэрт хийсэн нь хотын захын хорооны нөхцөл байдлыг судалж мэдээлэх сэдлээс үүдэлтэй. Кейсийн судалгаанд дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан болно:

1. Бэлгийн хүчирхийллээс бусад төрлийн хүчирхийлэл буюу бие махбодь, сэтгэл санаа, эдийн засгийн хүчирхийллийн тохиолдлуудыг хамруулах
2. 15-18 насныхан оролцсон тохиолдлууд байх
3. 28 дугаар хорооны нутаг дэвгэр дээр болсон тохиолдол байх
4. Сүүлийн 2-3 жилд тохиолдсон байх.

Үндсэн хоёр нэр томъёог дараах утгаар авч ашигласан болно:

1. Залуучуудын дундах хүчирхийлэл гэж гэрээс гаднах орчинд тохиолдсон, хоорондоо гэр бүл болон төрөл садны харилцаагүй, танил болон танил бус хүмүүс хоорондын хүчирхийллийн үйлдлийг авч үзэх²
2. Хүчирхийлэл гэсэн нэр томъёонд бие мах бодийн, сэтгэл санааны болон үл хайхрах хүчирхийллийн хэлбэрүүдийг багтаан ойлгож байгаа болно.

Судалгааны тайланг нийт 38 ярилцлагын мэдээлэлд тулгуурлан боловсрууллаа.

¹ Нээлттэй Нийгэм Форум болон Судлаач багш Б.Ариунсанаа нарын хамтран зохион байгуулсан “Кейсийн судалгааны арга зүй” сургалтын материалаас (2014 оны 9 сар)

² ДЭМБ-ийн тодорхойлолтыг үндэслэв

Нэгдүгээр бүлэг

Залуучуудын дундах хүчирхийллийн томьёолол

Залуучуудын дундах хүчирхийлэл гэж юу вэ?

Залуучуудын дундах хүчирхийлэл гэдэгт гэрээс гаднах орчинд тохиолдсон, хоорондоо гэр бүл, төрөл садны, мөн дотно харилцаагүй, танил болон танил бус 10-29 насны хүмүүс хоорондын хүчирхийллийн үйлдлийг багтааж үздэг байна.³ ДЭМБ хүчирхийллийг “Хэн нэгэн, эсвэл бүлэг хүмүүсийн эсрэг бие махбодид хүч хэрэглэн халдах, сэтгэл санааны гэмтэл, хэвийн хөгжилд саад учруулахуйц, амь насыг хохироох хүртэлх санаатайгаар үйлдсэн, үйлдэхээр заналхийлсэн аливаа тохиолдлыг хэлнэ” гэж тодорхойлжээ.⁴ Үүнээс дүгнэхэд, олон улсын түвшинд залуучуудын дундах хүчирхийлэлд өсвөр наснаас 30 хүртэлх насны хүүхэд, залуус олон нийтийн орчинд бие биедээ хүч хэрэглэх, дарамт үзүүлэх, заналхийлэх тохиолдлыг багтаан судалдаг байна.



Уг судалгаанд хүчирхийлэл гэсэн нэр томъёонд бие мах бодийн, сэтгэл санааны хүчирхийллийн хэлбэрүүдийг багтааж үзлээ. Насны бүлгийн хувьд 15-18 насны буюу нийгмийн харилцааны хувьд харьцангуй бие даасан ч эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгчдийн хараа хяналт дор байх насны бүлгийг сонгон судаллаа.

Олон улсын түвшинд залуучуудын дундах хүчирхийллийг нийгмийн эрүүл мэндийн ноцтой асуудал гэж үзэх болжээ. Залуучуудын дундах хүчирхийллийн төрөл хэлбэр болох бие биеэ дээрэлхэх, зодолдохоос эхлэн бэлгийн болон бие махбодийн хүчирхийлэл, халдлага, дарамт заналхийлэл нь залуу хүмүүсийн бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндэд уршигт үр дагавар үүсгэж, цаашилбал амиа хорлох юм уу амиа алдах явдалд хүргэж байгаа нь судалгаа, статистикаас тодорхой харагддаг тул нийгмийн эрүүл мэндийн салбарын асуудал гэж ханддаг байна.

Дэлхий дахинд 10-29 насны залуучуудын дунд жилд 200,000 гаруй хүн амины хэрэг гардаг бөгөөд тус асуудал нь энэ насныхны дундах нас баралтын шалтгааны дөрөвт жагсаж байна. Залуучуудын дундах гэмт хэрэг нь олон улсын болон улс орнуудын анхаарал татах асуудал болоод байна. Олон улсын хэмжээнд гарч буй хэргийг авч үзэхэд нийт хэргийн хохирогчдын 83 хувь нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд бүхий л улсад хүчирхийлэл үйлдэгчдийн дийлэнх нь эрэгтэйчүүд байдаг нь статистикаас харагддаг. Аль ч улс оронд эмэгтэйчүүдийн дундах хүн амины хэрэг эрэгтэйчүүдийнхээс бага байдаг.⁵ Хүний аминд хүрээгүй ч зодолдох, бие биеэ дээрэлхэх (bullying) асуудал залуучуудын дунд түгээмэл байна. Хөгжингүй 40 орчим улсад хийсэн судалгаанаас харахад нийт хөвгүүдийн 42 хувь нь, нийт охидын 37 хувь нь дарамт, хүчирхийлэлд ямар нэг байдлаар өртөж байжээ.⁶

Ид сурч хөгжих, хийж бүтээх насны залуучуудын дунд хүн амины болон хүний эрүүл мэндийг хохироосон хүндэвтэр хэргүүд нэлээд түгээмэл байдаг ба энэ нь зуурдаар нас барах, хөгжлийн бэрхшээлтэй болох, эрүүл мэнд, сэтгэл зүйн ноцтой асуудал үүсгэх зэргээр хувь хүний насан түршийн амьдралд нөлөөлөхөөс гадна орон нутаг, нийгэмдээ ч сөрөг нөлөөл үзүүлж байдаг нь тогтоогджээ. Энэ асуудал нь хохирогчийн гэр бүл, найз нөхөд болон олон нийтэд хүртэл сөргөөр нөлөөлдөг. Залуучуудын дундах хүчирхийлэл аливаа улс орны эрүүл мэнд, нийгмийн халамж болон хууль, шүүхийн салбаруудад илүү зардал үүсгэж, бүтээмжийг бууруулан, үр ашгийг багасгахад хүргэдэг болохыг судлаачид онцолж байна.

³ ДЭМБ-ийн тодорхойлолтыг үндэслэв

⁴ <http://www.who.int/violenceprevention/approach/definition/en/>-аас судалгааны багийн албан бус орчуулга

⁵ <http://www.who.int/mediacentre/factsheets/fs356/en/>

⁶ <http://www.who.int/mediacentre/factsheets/fs356/en/>

Залуучуудын дундах хүчирхийллийг онцлон судлах хэрэгцээ

Судалгаанаас үзэхэд 2000-2012 оны хооронд залуучуудын дундах хүн амины хэргийн гаралт өндөр хөгжилтэй орнуудад нэлээд буурсан ба хөгжингүй болон буурай орнуудад ийм ахиц гараагүй байна.⁷ Энэ нь нэг талаас амьдралын баталгаа, тогтвортой байдал, нийгмийн хэв журамтай холбоотой ч нөгөө талаас хөгжингүй улс орнуудад нийгмийн эрүүл мэнд, орон нутгийн хөгжлийн олон хөтөлбөр хэрэгжиж, хүний амьдралын чанар, эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд засан сайжруулах, сөрөг хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах зорилтот үйл ажиллагаа тууштай хэрэгжүүлдэгтэй шууд холбоотой ажээ.

Монгол Улсад залуучуудын дундах хүчирхийллийн асуудал нь хүчирхийлэл, хүүхэд, залуучуудын асуудлын хүрээнд хийгдсэн судалгаанд хавсарга байдлаар судлагдаж ирсэн байна. Тухайлбал, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр Халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин тогтоох үндэсний хэмжээний судалгааг 2005, 2009, 2013 онуудад тус тус хийжээ. Уг судалгаанд хүчирхийллийг халдварт бус өвчний төрөл хэлбэрт багтаан үзэж судлагдахуун болгож судалсан байна. 2009 онд хийгдсэн судалгааны тайлангаас харахад 15-24 насны эрэгтэйчүүдийн 89,9 хувь, эмэгтэйчүүдийн 60,8 хувь нь найз нөхөд болон гаднын танихгүй хүний зүгээс бие махбодийн хүчирхийлэлд өртсөн нь өсвөрзалуу үеийнхний дунд үе тэнгийн дарамт хүчирхийлэл их байгааг харуулж байгаа юм. Энэ байдал нас ахих тутам буурдаг тул хүчирхийлэл гарахаас сэргийлэх, хүчирхийллээс хамгаалах, нөлөөлөх нийгмийн үйлчилгээг 15-24 насны залуучуудад чиглүүлэх шаардлагатай байдгийг харуулж байгаа юм.


Түүнчлэн дээрх судалгаанд эрэгтэйчүүдийн 89,4 хувь нь хүчирхийлэлд өртсөн шалтгаанаа үзэл бодол зөрөлдсөний улмаас болсон хэмээсэн бөгөөд эрэгтэйчүүд өөр хоорондоо харилцааны аливаа зөрчилтэй асуудлыг шийдвэрлэхдээ 9 хүн тутмын нэг нь эв зүйгээр биш, хүч хэрэглэх аргаар шийдвэрлэдэг хандлага харагдаж байна гэжээ.⁸ Нийгмийн эрүүл мэнд, хүүхдийн болон нийгмийн хөгжлийн салбарт зөрчилдөөнийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх арга стратеги нэлээд олон байдгаас гадна эдгээр стратегийг ашиглан хүүхэд, залуучуудыг хамтын ажиллагаа, бүтээлч шийдэл, нийгмийн харилцаанд сургах олон хөтөлбөр байдаг.

⁷ <http://www.who.int/mediacentre/factsheets/fs356/en/>

⁸ ЭМЯ, “Халдварт бус өвчин, Осол гэмтлийн шалтгаан, Эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа”, УБ 2009 он

Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын захиалгаар ММСГ компани 2014 онд “Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа”-г хийсэн байна. Тус судалгаанд тусгайлан 18-24 насны залуучуудын дунд гэр бүлд болон сургууль, ажлын орчинд үйлдэгдэж байгаа хүчирхийллийг авч үзжээ. Судалгааны тайланд сургууль, ажлын орчинд үйлдэгдэж байгаа хүчирхийллийн хэлбэр, хувийг дараах байдлаар дүрсэлсэн байна.

График 1. Сургууль болон ажлын байранд тохиолдсон хүчирхийллийн хэлбэрүүд, хувиар



Сургууль, ажлын байранд тохиолдсон хүчирхийллийг судлахдаа үе тэнгийнхэн болон насанд хүрэгчдийн зүгээс үзүүлж байгаа хүчирхийллийг ялган авч үзсэн ба дээрх төрлийн хүчирхийллийг үе тэнгийнхэн нь насанд хүрэгчдийн зүгээс илүү үйлдэх хандлагатай байна.⁹ Өмнө дурдсанчлан, Монгол Улсад хийгдсэн судалгаанууд нь хүүхэд, залуучуудын хүчирхийллийг авч үзэхдээ голдуу гэр бүлийн орчинд, мөн эцэг, эх асран хамгаалагчдын зүгээс учруулж буй хүчирхийллийг судалж үзсэн байдаг. Хүүхэд хамгааллын хандлагаар насанд хүрсэн хүний зүгээс хүүхэд, өсвөр насныханд үзүүлж буй хүчирхийллийг судалж бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зайлшгүй шаардлагатай. Харин үүний зэрэгцээ үе тэнгийн залуучуудын дундах хүчирхийллийг мөн судлах хэрэгцээ байна.

Учир нь залуучуудын дундах хүчирхийллийн үр дүнд хүүхэд, залуучуудад дараах сөрөг нөлөө бий болдог ажээ.¹⁰ Үүнд:

⁹ ММСГ, “Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа” 2014, 33-37 хуудас

¹⁰ <http://www.education.vic.gov.au/about/programs/bullystoppers/Pages/impact.aspx>

- Өөртөө итгэх итгэл буурах
- Сэтгэл гутралд өртөх
- Ганцаардмал, зожиг болох
- Түгшимтгий болох
- Эмзэг мэдрэмтгий, дасан зохицох чадвар султай болох

Монгол Улсад залуучуудын дундах хүчирхийллийг судалсан байдал

- Бусдыг буруутгах, хий харддаг хандлагатай болох
- Хичээлийн идэвх буурах, цаашлаад хичээл таслах,
- Өөрийгөө тайвшруулахын тулд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх
- Бусадтай эрүүл харилцаа тогтооход асуудал үүсэх, улмаар бүлгээс тусгаарлагдах, ялгаварлагдан гадуурхагдах эрсдэлтэй.

Өсвөр насны хүүхэд анги, сургууль дотроо ганцаардмал, зожиг болж, өөртөө итгэл муутай, сэтгэлийн гутралтай байх юм бол сурах идэвх буурч, найз нөхдийн харилцаа, багш, насанд хүрсэн хүнд итгэх итгэл буурч ганцаардан өөрт нь туслах хүн байхгүй юм шиг санагдаж, сэтгэлийн дарамтад орж мэднэ. Энэ байдлаас болж эрүүл мэнддээ хортой, аюулгүй байдалдаа халтай зан үйл гаргаж эхлэх магадлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг аливаа судалгааны хавсарга байдлаар бус уг асуудлаар бие даасан судалгааг хийснээр хүчирхийллийн олон сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, аль хүрээнд ямар үйл ажиллагаа зохион байгуулахыг тодорхойлох, аливаа нэг орон нутгийн онцлогийг тусгасан мэдээлэлтэй болох боломжтой юм. Хэрэв залуучуудын дундах асуудал судлагдахгүй хэвээр байвал тус асуудал нь ужгирч, ид хийж бүтээх насны залуу хүмүүст ноцтой хохирол учруулах сөрөг хүчин зүйлээс хамгаалж чадахгүйд хүрч болох юм.

Хоёрдугаар бүлэг

Залуучуудын дундах хүчирхийллийг бууруулахад нөлөөлөх арга хэмжээ

Бодлогын баримт бичгүүд гаргах


Залуучуудын дундах хүчирхийллийг бууруулах талаар олон улсад байгаа туршлага, судалгаа нь энэ асуудлаар ажиллаж эхэлж байгаа бидэнд мэдлэг, туршлага болох юм.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ДЭМБ, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын хамтран гаргасан “Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэлхий дахины хандлага 2014”¹¹ судалгаанд хамрагдсан 133 улс орны талаас илүү нь залуучуудын дундах хүчирхийлэлд анхаарсан үндэсний



хөтөлбөр хэрэгжүүлдэг боловч зөвхөн дөрөвний нэг нь л залуучуудын дундах хүчирхийллийн мөн чанар, үр дагавар, эрсдэлт хүчин зүйлсийг судлан тодорхойлох судалгаа явуулсан тухай тайланд дурджээ. Тус үр дүнг График 2-т харуулав.¹²

График 2. Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэлхийн улс орнуудын хандлага



Эх сурвалж: “Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэлхий дахины хандлага 2014”
(НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, ДЭМБ, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар)

Тайлангийн дүнгээс харахад залуучуудын дундах хүчирхийллийг бууруулахад дараах хөтөлбөрүүд үр дүнтэй байдаг байна:

- Сургуулийн өмнөх боловсролын хүрээг цэцэрлэгээр хязгаарлахгүй хүүхдүүдийг сургуульд амжилттай суралцах үр чадварт сургах нэмэлт үйл ажиллагаа тусгах. Сургуульд бэлтгэх хөтөлбөрүүд нь хүүхдүүд анги, сургууль дээрээ өөртөө итгэлтэй байж, найз нөхөд, багш, сурган хүмүүжүүлэгчидтэй эерэг харилцаа тогтоон, амжилттай суралцахад дэмжлэг болдог тул өсвөр болон залуу насандаа гэмт хэрэгт холбогдох байдлыг 40 хувиар бууруулж чадна гэж үзжээ.

¹¹ Тус тайлан нь нийт 133 орны нийгэмд үүсч буй хүчирхийллийн асуудлууд буюу нэн ялангуяа хүүхдэд зүй бус хандах, залуучуудын дундах хүчирхийлэл, гэр бүл болон бэлгийн хүчирхийлэл, ахмад настны хүчирхийлэл зэрэг асуудлуудын талаар авч буй үндэсний арга хэмжээг үнэлэн тодорхойлсон анхны тайлан юм.

¹² http://www.who.int/violence_injury_prevention/violence/status_report/2014/report/Youth_violence.pdf

¹³ http://www.who.int/violence_injury_prevention/violence/status_report/2014/report/Youth_violence.pdf

- Хүүхэд, залуучууд үүр бүхимдлаа зохицуулах, зөрчлийг шийдвэрлэх болон асуудлыг эв дүйгээр шийдвэрлэх харилцааны үр чадваруудыг эзэмшихэд чиглэсэн амьдрах ухааны сургалтууд;
- Эрсдэл бүхий гэр бүлийн орчинд өсөж байгаа, мөн эрсдэлтэй зан үйл гаргаж байгаа хүүхэд, залуучуудыг эерэг загвар болох насанд хүрсэн хүнтэй танилцуулах зөвлөхийн хөтөлбөр;
- Дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд зэрэг байна¹³.

Монгол Улсын хувьд “Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2006 онд батлан, 2015 оныг дуустал 3 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд 15-24 насны залуучуудыг бие даасан бүлэг болгон өсвөр үе, залуучуудыг аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлийг өөрчлөх таатай орчныг бүрдүүлнэ гэсэн зорилт дэвшүүлжээ.

Мөн цаашлаад Монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршдаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болж төлөвшүүлэх гэр бүл, боловсрол, нийгмийн орчныг бүрдүүлэх зорилготой “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байна. Үүнээс гадна боловсролын шинэчлэлийн хүрээнд салбарын яамнаас “Авьяас”, “Ном”, “Хүүхэд бүрийг хөгжүүлье” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.

Дээр дурдсанчлан манай орон хэдийгээр хүүхэд, залуучуудад чиглэсэн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа ч өнөөгийн нийгэмд, дэлхий дахинд тулгамдаад буй залуучуудын дундах хүчирхийллийн асуудлыг онцгойлон анхаарч байгаа нь мэдрэгдэхгүй байна. Манай орны хувьд энэхүү асуудлыг нарийвчлан судлан шалтгаан, үр дагаврыг тодорхойлох, цаашлаад судалгаанд суурилсан зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тус тайлангийн үр дүн ч мөн батлан харуулж байна.

Гуравдугаар бүлэг

Судалгааны үр дүн: Судалгаа явуулсан орон нутаг дахь залуучуудын дундах хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал

БЗД-ийн 28 дугаар хорооны нөхцөл байдал

Тус хороо Улаанбаатар хотоос 20 км алслагдсан хотын захын дүүрэгт байрладаг онцлогтой. Нийт 7,695 хүнтэй бөгөөд үүнээс 2,000 гаруй нь шилжин суурьшсан иргэд, 1,495 нь 15-24 насны залуучууд байна. Тус хорооны бас нэгэн онцлог нь иргэд зуны улиралд зуслангийн зориулалтаар түр хугацаанд нүүж ирдэг явдал юм.

Орон нутгийн дээрх онцлогийг судалсны дараа тус хороонд бүртгэгдсэн, бүртгэгдээгүй хүчирхийллийн тохиолдлыг тандах зорилгоор 2014 оны 11 дүгээр сард залуучуудын дундах хүчирхийллийг илрүүлэх судалгааг хийсэн. Энэ судалгаагаар сургуулийн насны хүүхдүүдийн дунд гарсан хүчирхийллийн зарим нэг тохиолдлын тухай иргэд, сургуулийн сурагчид, сургуулийн ажилтнуудаас олж мэдсэн ба үүнээс харахад 15-18 насны буюу ахлах ангийн хүүхдүүдийн дунд:



- Сургуулийн орчинд нэгнийгээ дээрэлхэх, дарамтлах, айлган сүрдүүлэх болон эд зүйлийг нь булааж авах, эвдэх;
- Хорооны 4 болон 5 дугаар хэсгийн орчинд хүүхдүүд бүлэглэн зодолдох, нэгнийгээ болон бусдыг дээрэмдэх тохиолдол гарчээ.

Харин 19-24 насны буюу оюутан, хөдөлмөр эрхлэх насны залуучууд хотын төвд сургуульд сурдаг, эсвэл ажил хийдэг, чөлөөт цаг өнгөрүүлэх газар хорооны нутаг дэвсгэрт байхгүй тул өдрийн ихэнх цагийг тухайн орон нутагт бус хотын төвийн дүүргүүдэд өнгөрүүлдэг байна. Тиймээс 19-өөс дээш насны залуучуудын дунд гарсан хүчирхийллийн тохиолдол энэ судалгааны явцад илрээгүй болно. Хэдий тийм ч энэ нөхцөл байдал нь хороонд иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин байхгүй асуудлыг гаргаж ирснээрээ энэ судалгааны шууд бус нэг үр дүн болж байгаа юм. Улмаар хотын захын энэ хорооны иргэдийн амьдрах орчны ая тухыг нэмэгдүүлэх, хорооны иргэд чөлөөт цагаа хамтран өнгөрөөх замаар иргэдийн нэгдэл, нягтралыг бий болгохын тулд энэ асуудалд анхаарах хэрэгцээ шаардлага байгааг онцолж байна.

Хорооны албан хаагчид, хэсгийн ахлагч, цагдаа, дэлгүүрийн ажилтнуудын өгч байгаа мэдээллээр тухайн хороонд хүчирхийлэл үйлддэг залуучуудын зохион байгуулалттай тогтсон бүлэг, бүлэглэл байхгүй байна.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад насанд хүрэгчид хотын төвд ажил сургууль эрхлэх, чөлөөт цагаа өнгөрөөхөөр яваад эзгүй байх үеэр өсвөр насныхан нэгнийдээ цуглан архи уух, согтуугаар зодолдон нэгнийхээ бие эрхтэнд гэмтэл учруулах, эд зүйлийг булаах, дээрэмдэх, бусдыг айлгах явдал гардаг зэрэг мэдээлэл ирсэн боловч цаашид дэлгэрүүлэн судлах эх сурвалж хангалттай бус байсан учраас эдгээр тохиолдлыг судалгаанд ашиглаагүй болно.

Судалгааны баг орон нутгийн иргэд болон хорооны албан хаагчдаас тухайн хорооны нөхцөл байдлын талаар мэдээлэл авах зорилгоор орон нутгийн зураглалыг хамтдаа хийсэн бөгөөд уг судалгаанаас харахад тус хороо нь дараах онцлогтой байна:

- Хороо нь 5 хэсэгтэй ба 4, 5 дугаар хэсэгт дэд бүтэц хамгийн муу. Тус хэсгүүдэд гудамжны гэрэлтүүлэг байхгүй. Мөн иргэд цэргийн анги болон айлуудаас цахилгаан татаж өрхийн хэрэглээгээ хангадаг боловч энэ нь наад захын хэрэглээ болох хоол хийх, цай чанахад ч хангалттай хүрэлцдэггүй байна. Бусад хэсгүүдийн хувьд гэрэлтүүлэг, тогны хүрэлцээ харьцангуй сайн. Иргэд Хужирбулан, Гачуурт чиглэлийн нийтийн тээврээр ихэвчлэн үйлчлүүлдэг. Хэдийгээр автобусны үйлчилгээтэй боловч удаан хүлээх тохиолдол гардаг.
- Иргэдийн хамгийн их санаа зовоосон асуудал бол 4, 5 дугаар хэсгийн гудамжны гэрэлтүүлэг муу байгаа явдал байна. Түүнчлэн энэ хэсгээс сургууль хүрэх автобус байхгүй тул хүүхдүүд харанхуйд сургууль руугаа 2-3 км орчим алхаж хүрдэг. Үүнээс үүдэн эцэг, эх, эмээ, өвөө нар

хүүхдэдээ санаа зовох, хүүхдүүд өөрсдөө айх, харанхуйд хүүхэд, хөгшид халтирч унах, нохойд уруулах зэрэг асуудал гардаг байна. Мөн хорооны хэмжээнд сул нохой их байгаа нь иргэдийн санааг зовоосон өөр нэгэн асуудал болдог аж. Ялангуяа сургуулийн орчимд нохойноос хүүхдүүдийг хамгаалах шаардлага байна.

- Нийт хүн амын дунд ахмад настнуудын эзлэх хувь өндөр;
- Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг өнгөрүүлэх газар хомс;
- Банк, номын сан, үсчин болон хүнсний зах зэрэг үйлчилгээг орон нутагтаа авах боломжгүй. Мөн тухайн орон нутагт Христийн 3 сүм байдаг ба ихэвчлэн хүүхдүүд тэдгээр сүмээр үйлчлүүлдэг байна.

Кейсийн судалгаагаар илэрсэн хүчирхийллийн хэлбэр, үр дагавар, зөрчлийг шийдэж буй арга зам

Энэ хэсэгт бид илрүүлэх түвшний судалгаагаар тогтоогдсон хүчирхийллийн тохиолдлын дагуу хохирогч хүүхдүүд, тэдний найз нөхөд, гэр бүлийн гишүүд болон багш, нийгмийн ажилтантай ярилцсанаа нэгтгэн танилцууллаа. Ингэхдээ хүчирхийллийн хэлбэр, шалтгаан, үр дагавар, асуудлыг шийдвэрлэсэн байдал болон онцлог шинж гэсэн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийлээ.

Кейс 1:

Хүчирхийллийн хэлбэр: Бие махбодь, сэтгэл санааны хүчирхийлэл болон эдийн засгийн сэдэлтэй дарамт

Болсон үйл явдал: Шинээр шилжиж ирээд удаагүй байгаа сурагчаас өөр нэг сурагч удаа дараа мөнгө нэхэхэд нь өгөөгүй учир тэдний хооронд зөрчил үүссэн байна. Улмаар зөрчил гүнзгийрч нэг удаа түүний цамцан дээр балаар сараачсан бөгөөд түүний үйлдэлд уурлаж, зодоон үүссэн.

Үр дагавар: Зодоон үүссэнээс хойш хохирогч сэтгэлээр унах, бүхимдах болсон, мөн цамцаа алдаж дахин шинээр худалдан авах шаардлагатай болсон.

Асуудлыг шийдвэрлэхэд авсан арга хэмжээ: Хүчирхийлэлд өртсөн сурагчийн зүгээс өөрийн асран хамгаалагч болох ахдаа учир явдлыг тайлбарлаж, асуудлыг шийдвэрлэхэд тусламж хүссэн. Харин түүний ах нь тухайн хүүхэдтэй уулзаж ахиж ийм асуудал гаргахгүй байх талаар сануулга өгсөн.

Анги удирдсан багш (АУБ), нийгмийн ажилтан (НА) нарын зүгээс мөн харилцааны зөрчил гаргахгүй байхыг сануулаад л өнгөрсөн бөгөөд шинэ цамц худалдан авч өгүүлэхээр шийдвэрлэсэн. Гэвч тухайн сурагч шинэ цамц авч өгөөгүй бөгөөд хохирогч хүүхэд өөрөө шинээр цамц худалдан авсан.

Онцлог шинж: Тус сургуульд шинээр шилжиж ирсэн сурагчийг ялгаварлан гадуурхах, дарамтлах байдал ажиглагдаж байгаа нь энэ кейсээс харагдаж байна. Мөн АУБ, НА-ы зүгээс үр дүнтэй арга хэмжээ авч чадаагүй мөн АУБ нь тухайн хүчирхийлэл үйлдсэн сурагч сургуулиасаа шилжсэн тохиолдолд дахин асуудал үүсэхгүй гэж бодож байгаа нь ярилцлагаас харагдсан.

Кейс 2:

Хүчирхийллийн хэлбэр: Сэтгэл санааны хүчирхийлэл болон эдийн засгийн сэдэлтэй дарамт

Болсон үйл явдал: Нэгэн сурагч хотын төв орох гэж байгаа учраас түр хэрэглээд эргээд өгье гэж ангийнхаа хүүхдийн шинэ гар утсыг авсан. Гэсэн хэдий ч гар утсыг нь буцаан өгөөгүй ба хохирогч гар утсаа эргүүлэн авъя гэхээр өөрт нь байхгүй гэдэг боловч хэрэглэсээр байгаа болохыг дурдсан.

Үр дагавар: Өөрийн эд зүйлээ алдсанаас хойш хохирогч уурлах, үзэн ядах байдал үүссэн бөгөөд сэтгэл санааны хувьд хүнд байгаа, мөн эдийн засгийн хохиролтой байгаагаа ярилцлагын үед илэрхийлсэн.

Асуудлыг шийдвэрлэхэд авсан арга хэмжээ: Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд хохирогч тухайн сурагчтай ярилцаж, утсаа эргүүлж авах хүсэлт тавьсан ч амжилтад хүрээгүй. Мөн энэ талаар АУБ болон ээж, аавдаа мэдэгдсэн. Асуудлыг шийдвэрлэхэд дээрх талууд үр дүнтэй алхам хийгээгүй бөгөөд аав, ээж нь АУБ-ийг асуудлыг шийдвэрлэнэ гэж найдсан. Цаашлаад хэрэв утсыг эргүүлэн өгөхгүй байвал асуудлыг мартаж, орхихыг аав нь зөвлөсөн.

Онцлог шинж: АУБ-ийн үзэж байгаагаар хүүхдүүд өөрийн эрх мэдэл, нэр хүндийг тогтоохын тулд хүч хэрэглэх нь түлхүү байдаг байна. Мөн хотын захын орон нутагт амьдарч байгаа хүүхдүүд хотын төв хэсэг рүү зорчихдоо аль болох шинэ, орчин үеийн эд зүйлс хэрэглэхийг хичээж байгаа нь энэ кейсээс харагдаж байгаа юм. Магадгүй нийгэмд, үеийнхэндээ хүлээн зөвшөөрөгдөхийн тулд бусдын эд зүйлсийг булаах, зөвшөөрөлгүй авах, хууран мэхлэх зэрэг арга хэрэглэдэг байж болзошгүй.

Кейс 3:

Хүчирхийллийн хэлбэр: Сэтгэл санааны хүчирхийлэл болон эдийн засгийн сэдэлтэй дарамт, ялгаварлан гадуурхах, хохирогч хүүхдийг ганцаардуулж дарамтлах

Болсон үйл явдал: Нэгэн сурагчийн биеэ авч яваа байдал болон түүний чадвар, хувь хүний онцлог нь ангийн бусад сурагчдад таалагдахгүй байсан учраас тухайн сурагчийг үг хэлээр доромжлох, спортын болон урлагийн арга хэмжээнд оролцуулахгүй байх шийдвэрийг нийтээрээ үгсэн гаргасан болохыг ангийнх нь хүүхэд хэлсэн. Мөн нийгмийн ажилтан тухайн хүүхэд болон ангийн бусад хүүхдийн хооронд зөрчил гарсныг хэлсэн.

Асуудлыг шийдвэрлэхэд авсан арга хэмжээ: Өөрийн асуудлыг ээждээ хэлсэн бөгөөд хохирогчийн ээж нь ангийн хүүхдүүдтэй нь уулзалт зохион байгуулсан. Мөн хохирогч мөнгөтэй үед ангийнхан нь зерэг ханддаг болохоор ангийнхныхаа бодлыг өөрчлөхийн тулд мөнгө зарцуулах болсон гэж ангийнх нь сурагч хэлсэн. Ангийн хурлаар хохирогчтой харилцах харилцаагаа сайжруулахаар шийдвэрлэсэн.

Үр дагавар: Үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны асуудлаас болж сэтгэл санааны тогтворгүй байдал үүсэж улмаар хичээл таслах, хичээлд оролцохгүй байх болсон. Мөн ангийнхандаа таалагдахын тулд бусдад мөнгө зарцуулсан. Нийгмийн ажилтны үзэж байгаагаар тухайн хүүхэд хичээлд явах сонирхол нь буурсан, чөлөөтэй байж чаддаггүй, найз нөхөдгүй болох байдал ажиглагдсан байна.

Онцлог шинж: Бусад кейстэй харьцуулахад энэ кейс нь анги нийтээрээ нэг сурагчийг гадуурхаж байгаа онцлогтой байна.

Кейс 4:

Хүчирхийллийн хэлбэр: Бие махбодийн болон сэтгэл санааны дарамт

Болсон үйл явдал: Хохирогчийн ангид суралцдаг нэгэн сурагч уур бухимдлаа зөвөөр удирдаж чаддаггүй, өөрийн эрх мэдлийг ангидаа тогтоох хүсэлтэйгээс болж бусдыг үг хэлээр доромжилж, аливаа харилцааны зөрчил, маргааныг ойлголцох, зөвшилцөх биш хүчээр шийдвэрлэх хандлагатай байдаг гэж хохирогч үзэж байна.

Асуудлыг шийдвэрлэхэд авсан арга хэмжээ: Тухайн сурагчтай муудалцах, зөрчилдөхгүйн тулд аль болох түүнтэй харилцахаас зайлсхийдэг. Ангийн хүүхдүүдийн зүгээс тухайн хүчирхийлэл үйлдэгч сурагчид сануулж хэлж, ангийн хурлаар хэлэлцдэг.

Үр дагавар: Тухайн сурагчтай харилцаанд орох үед уурлаж бухимдах болсон. Цаашлаад ангийн ерөнхий уур амьсгал сөрөг болох, сурагч хоорондын харилцаанд хүчирхийллийн шинжтэй үйлдлүүд давамгайлах байдал үүсэж болзошгүй.

Онцлог шинж: Ангийн нэг сурагчийн уур бухимдалтай, бусдыг хүчирхийлэх зан үйл нь ангийн ерөнхий уур амьсгалд сөргөөр нөлөөлж, сурагчдад таагүй орчныг үүсгэж байна.

Дүгнэлт

Баянзүрх дүүргийн 28 дугаар хороонд 2014 оны 11-12 дугаар сард цуглуулсан мэдээлэлд үндэслэсэн залуучуудын дундах хүчирхийллийг судлах кейсийн судалгааны үр дүнд тус хорооны нутаг дэвсгэрт 15-18 насны залуучуудын дунд сургуулийн орчинд болон олон нийтийн орчинд нэгнийгээ хүчирхийлэх тохиолдлууд гарч байгааг илрүүллээ.

Сургуулийн орчинд тохиолдож байгаа хүчирхийлэл нь мөнгө болон түүнтэй холбоотой асуудал, мөн зөрчлөөс шалтгаалан үйлдэгдэж байна. Хүчирхийлэлд ихэвчлэн сургууль болон тухайн орон нутагт шинээр шилжин ирсэн, найз нөхөд багатай хүүхэд залуучууд өртөж байгаа нь харагдсан. Хүчирхийллийн түгээмэл хэлбэр нь тухайн залуучуудын эд зүйлийг авах зорилгоор хүч хэрэглэх, хувийн эд зүйлийг булаах, бие махбодийг гэмтээх, ялгаварлан гадуурхах, нэр хоч өгөх, дарамтлах, сэтгэлээр унагаах зэрэг байна. Дээр дурдсан хүчирхийлэл нь ихэвчлэн сургуулийн ангид, сурагчдын чөлөөт цагаа өнгөрүүлдэг газар тохиолдож байна. Хүчирхийллийн улмаас хохирч буй залууст өөрсдийгөө анги, хамт олноос тусгаарлах, эд материалаараа хохирох, уур, уцаартай болох, сэтгэл шаналах зэрэг сөрөг үр дагавар гарч байгааг энэ судалгаа харууллаа.



Харин хорооны олон нийтийн газарт үйлдэгдэж байгаа залуучуудын дундах хүчирхийлэл нь эдийн засгийн сонирхлоор нэгэндээ хүч хэрэглэн халдах, зөрчлөөс болж хоорондоо зодолдох, мүүдалцах зэрэг хэлбэрээр илэрч байна. Энэ төрлийн хүчирхийлэл байгаа гэдгийг хэд хэдэн оролцогч дурдсан боловч тухайн төрлийн хүчирхийллийн шалтгаан, хохирогчийн талаар дүгнэлт, төсөөлөл гаргахад мэдээллийн ялгаатай байдал хүндрэл учруулж байлаа. Зарим эх сурвалжийн мэдээллээс харахад жижиг бүлгүүдийн зодоон, мүүдалцаан нь тухайн бүлгийн эрх мэдлээ бататгах зорилготой холбоотой байж болох юм.

Сургуулийн орчинд болон орон нутагт үйлдэгдэж байгаа аль ч төрлийн хүчирхийлэл нь далд хэлбэртэй, хохирогчтой холбоо бүхий цөөн хүмүүс л мэдэж байгаа онцлогтой байлаа. Энэ нь залуучууд асуудлыг даамжруулах сонирхолгүй, тухайн хүчирхийлэл дахин тохиолдохоос аль болох зайлсхийх байдлаар асуудлыг шийдвэрлэх хандлагатай байгаатай холбоотой. Түүнчлэн асран хамгаалагчид, албаны хүмүүсийн хувьд тухайн асуудал даамжраагүй, дахин давтагдаж өөрт нь мэдэгдээгүй бол орхих хандлагатай байлаа. Мөн албан ёсоор бүртгэх нь бага байна. Нөгөө талаас, энэ байдал нь үргэлжлүүлэн авах арга хэмжээ, хөтөлбөр, дэмжлэгийн арга хэрэгсэл байхгүйтэй голдуу холбоотой байдаг ба хүчирхийллээс сэргийлэх хувь хүн, бүлэг, олон нийтийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эхлүүлснээр хүчирхийллийн анхны илрэлээр бага, хөнгөн гэлгүй арга хэмжээ авагдах боломжтой болох юм.

Асуудлаас зайлсхийх хэлбэрээр шийдвэрлэж байгаа уг арга нь хүчирхийллийг бүрэн шийдвэрлэж чадахгүй байгаагаас гадна хүчирхийлэл үйлдэж байгаа залуучууд дахин өөр залуучуудыг хүчирхийлэх, өөрсдийн гаргасан үйлдлээ шүүмжлэхгүй байх зэрэгт нөлөөлж байна. Энэ нь ч бидний судалгаанд оролцогчид хүчирхийлэл үйлдэж байгаа залуучуудын найз нөхөд тухайн үйл явдал болоход дэргэд нь байсан боловч болиулах гэж оролдоогүй харин инээж, баярлаж байсан, эсвэл тухайн залуучууд үүнийгээ бахархал болгон хүлээж авдаг гэж тайлбарлаж байснаар харагдаж байгаа юм.

Судалгааны явцад хүүхдүүд, тэдний гэр бүл, ангийн багш, найз нөхөд, сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагуудаас харахад хүчирхийллийн үйл явцыг дараах байдлаар дүрсэлж болохоор байна.

Сургуулийн орчин дахь хүчирхийллийн үйл явц



Уг судалгааны үр дүн нь өмнө хийгдсэн судалгааны үр дүн болон залуучуудын дундах хүчирхийллийн сөрөг үр дагавруудтай нийцэж байна. Жишээлбэл, өмнө дурдсан судалгаанд залуучуудын дундах хүчирхийлэл нь ихэвчлэн таньдаг хүмүүсийн дунд үйлдэгддэг, үе тэнгийнхний дарамт хэлбэртэй байна гэсэн нийтлэг дүр төрхтэй мөн нийцэж байгаа юм.

Зөвлөмж

Судалгааны үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг боловсрууллаа.

Сургуулийн орчинд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Сургуулийн захиргаа:

- “Эрдэм”, “Авьяас”, “Зөв монгол хүүхэд” гэх мэт хөтөлбөрийн дагуу багш нарын хичээлийн агуулгад хүүхдийн хөгжлийн асуудлыг тусгах, үүний нэг хэсэг нь зөрчлийг эв зүйгээр шийдэх, багаар ажиллах, бухимдлаа хүчирхийллийн бус арга замаар илэрхийлэх зэрэг амьдрах ухааны аргуудын тухай агуулга байх. Энэ агуулгыг мөн багшийн хуваарьт багтсан ангийн ажилд ашиглаж болохоор зохицуулах;
- Хүүхэд, өсвөр насныхан чөлөөт цагаараа очих газар, авах үйлчилгээ орон нутагт алга байгаа тул хичээлийн дараах хөтөлбөрүүдийг нийгмийн ажилтны оролцоотойгоор бий болгон хэрэгжүүлэх. Ингэхдээ хүүхдүүдээс хэрэгцээний судалгаа авсан байх;
- Хичээлийн дараах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн иргэд, идэвхтнүүдийг оролцуулах. Жишээлбэл, тэтгэвэрт гарсан мэргэжил, түршлагатай сайн дурынхны оролцоог зохион байгуулж ажиллах. Ингэснээр хичээлийн бус цагийн хөтөлбөрийн зардал багасаж, төрөл хэлбэр нэмэгдэх сайн талтай;
- Хичээлийн дараах хөтөлбөрийг хэрэгжүүлэх анги танхимаар хангах;
- Багшийн ажлын үнэлгээнд хичээлийн хөтөлбөрт хүүхэд хөгжлийн асуудлыг тусгасан байдал болон хичээлийн дараах хөтөлбөрт оролцсон байдлыг тусгах;
- Хорооны цагдаа зэрэг албан хаагчид, эцэг эхчүүдтэй хамтран хүүхэд залуучуудад мэдээлэл өгөх.
- Сургуулийн нийгмийн ажилтны үйл ажиллагаанд дараах асуудлыг тусгах:
 - Сурагчдын дунд үе тэнгийн сургагч багш нарыг бэлтгэн хүч хэрэглэхгүйгээр зөрчлийг шийдвэрлэх, хүчирхийлэлгүй орчин зэрэг сэдвээр сургалт, мэдээллийн кампанит ажил зохион байгуулах;
 - Залуучуудын дундах хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд, хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй хүүхдэд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн хөтөлбөрт хамруулах;
 - Залуучуудын дундах хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд, хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй хүүхэд болон тэдний эцэг, эхчүүдтэй хэрхэн ажиллах тухай зөвлөгөөг анги удирдсан багш нарт өгөх.

- Анги удирдсан багш нарын үйл ажиллагаанд дараах асуудлыг тусгах:
 - Өсвөр, залуу насныхны хөгжлийн онцлог болон залуучуудын дундах хүчирхийллийн талаарх өөрсдийн мэдлэг, мэдээллээ дээшлүүлэх;
 - Залуучуудын дундах хүчирхийллийн хохирогч болох эрсдэлтэй хүүхэд, хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй хүүхдийг ажиглан, сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээнд хамруулах;
 - Эцэг, эх болон сурагчдыг хамтарсан байдлаар сургалтын үеэр болон сургалтаас гадуурх үйл ажиллагаанд оролцуулах, энэ төрлийн үйл ажиллагааг олон төрлөөр зохион байгуулах;
 - Залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчдын чөлөөт цагийн үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийж хэрэгцээнд нь тохирсон клуб, дугуйлан, секцийг шинээр бий болгох;
 - Сургууль дээр хэрэгжиж байгаа клуб, дугуйлан, секцийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх судалгааг тогтмол хийж байгууллагын удирдлага, багш нар, эцэг эх болон сурагчдад судалгааны үр дүнг мэдээлэх.

Орон нутагт авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хорооны удирдлага, захиргаа дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх боломжтой:

- Залуучуудын чөлөөт цаг өнгөрүүлэх газрууд болон соёл, боловсролын үйлчилгээний нэр төрлийг тухайн орон нутагт нэмэгдүүлэх чиглэлээр Улаанбаатар хотын захиргаатай хамтран ажиллах;
- 120 дугаар сургуулийн удирдлага, багш нартай хамтран тус орон нутагт амьдарч байгаа нийт эцэг, эхчүүдэд хүүхэд, залуучуудад зориулсан чөлөөт цагийн арга хэмжээг сургуулийн нөөцөд тулгуурлан зохион байгуулах;
- Хорооны хүүхэд, залуучуудад аюултай орчнүүдыг судалж, тодорхойлон тухайн орчныг сайжруулах үйл ажиллагааг олон нийтийн цагдаа, эцэг эхчүүд, сургууль зэрэг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

Ашигласан материал

Монгол хэл дээрх материалууд

1. ЭМЯ, “Халдварт бус өвчин, Осол гэмтлийн шалтгаан, Эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа”, УБ 2009 он
2. Нийслэлийн хүүхэд , гэр бүл хөгжлийн төв, ММСГ ХХК, “Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа” 2014,

Англи хэл дээрх материалууд

1. *Yoouth Crime Prevention, Nancy Guerra*

https://www.oas.org/dsp/documentos/pandillas/2sesion_especial/BANCO%20MUNDIAL/Final_Youth_%20Violence_%20Prev_%20ENG.pdf

2. *Global Status Report on Violence Prevention 2014*

http://www.who.int/violence_injury_prevention/violence/status_report/2014/en/

3. *Вэб сайт, цахим мэдээллийн эх сурвалжууд*

1. <http://www.meds.gov.mn/post1312121>
2. <http://www.legalinfo.mn/annex/details/5962?lawid=9349>
3. <http://www.legalinfo.mn/annex/details/2772?lawid=3628>
4. <http://www.who.int/violenceprevention/approach/definition/en/>
5. <http://www.education.vic.gov.au/about/programs/bullystoppers/Pages/impact.aspx>
6. <http://www.who.int/mediacentre/factsheets/fs356/en/>

Тэмдэглэл
